

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 2-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-16

1.Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны
100 жилийн ойд зориулсан Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн
хуралдаан 5-16

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 26-ны өдөр /Мягмар гараг/-ийн
Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100
жилийн ойд зориулсан Монгол Улсын Их Хурлын
хүндэтгэлийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан хүндэтгэлийн хуралдааныг даргалав.

Хүндэтгэлийн хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 78 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Ч.Анар, Б.Батбаатар, Р.Батболд, Б.Бейсен, С.Бямбацогт, Ж.Галбадрах, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Х.Ганхуяг, М.Ганхүлэг, Ж.Золжаргал, М.Мандхай, П.Наранбаяр, Д.Рэгдэл, Р.Сэддорж, Ж.Энхбаяр;

Чөлөөтэй: Б.Батцэцэг, Д.Бум-Очир;

Эмнэлгийн чөлөөтэй: З.Мэндсайхан;

Тасалсан: Т.Аубакир, Ц.Баатархүү, Д.Батбаяр, Ж.Батжаргал, Х.Баттулга, Л.Гантөмөр, Б.Жаргалан, Э.Одбаяр, Х.Тэмүүжин, Г.Тэмүүлэн, А.Ундраа, Б.Чойжилсүрэн, Д.Энхтуяа.

**Нэг.Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль
баталсны 100 жилийн ойд зориулсан Монгол Улсын Их Хурлын
хүндэтгэлийн хуралдаан**

“Их хуралдай” танхим дахь Монгол Төрийн сүлдний дэргэд хүндэт харуулууд зогсож, Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүд суудлаа эзэлсэн байлаа.

Танхимын баруун, зүүн хойд болон урд дэлгэц дээр “БҮГД НАЙРАМДАХ УЛСЫГ ТУНХАГЛАЖ, АНХДУГААР ҮНДСЭН ХУУЛЬ БАТАЛСНЫ 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН, 2024.11.26” гэж бичсэн байв.

Танхимын баруун хойд талд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Л.Өлзийсайхан, Д.Гангабаатар, Ж.Эрдэнэбулган, Р.Батрагчаа, Б.Болдбаатар, Ц.Цолмон, Э.Энхтуяа, О.Мөнхсайхан, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх Н.Отгончимэг, Н.Булгантамир, С.Сайхансанаа, Р.Алтангэрэл, Д.Золжаргал, Ч.Урангоо;

Танхимын зүүн хойд талд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан, Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Бямбажаргал, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Монгол Улсын Их Хурлын дарга асан Ц.Нямдорж, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн

дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын дэд дарга Э.Лхагва, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Т.Төрболд, Монгол Улсын Их Хурлын даргын шадар туслах Б.Ундрахбаяр, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Менежментийн газрын дарга Ц.Батбаатар, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах, Дотоод хяналтын хэлтсийн дарга Б.Төгсцэнгэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Гадаад харилцааны газрын дарга П.Баярмагнай, Хэвлэл мэдээллийн газрын дарга Э.Болортуяа, Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Үнэнбат;

Танхимын дээд лоожид Монгол Улсад суугаа гадаад орнуудын Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нар болон гадаадын зочид, төлөөлөгчид суудлаа эзэлсэн байв.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын сурталчилгааны хэлтсийн дарга Ж.Эрдэнэбаяр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Их Хуралдай” танхимд морилон ирж байгааг зарлахад хуралдаанд оролцогсод босож хүндэтгэл үзүүлэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж Төрийн ордны хамгаалалтын хэлтсийн хамгаалалт дор “Их хуралдай” танхимд тусгайлан зассан индэрт залав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойд зориулсан Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан нээснийг мэдэгдэв.

Танхимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд болон хуралдаанд оролцогсод босож хүндэтгэл үзүүлэв.

Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч үг хэлж дуусахад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлсэн Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхэд талархал илэрхийлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг танилцуулж дууссаны дараа хүндэтгэлийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдэв.

Хүндэтгэлийн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хүндэтгэлийн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтэс хариуцан ажиллав.

Хүндэтгэлийн хуралдаан 38 минут үргэлжилж, 126 гишүүнээс 93 гишүүн хүрэлцэн ирж, 73.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
11 цаг 03 минут.

ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Хөтлөгч: Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд оролцохоор Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Төрийн ордны Их хуралдай танхимд морилон ирж байна.

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд, хүндэт зочид, гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар аа,

Бүгд Найрамдах Улсаа тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойд зориулсан Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Барсүрэнгийн Баасандорж зална.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан Төрийн ордны Их хуралдай танхимд зохион байгуулагдаж байна.

Хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Засгийн газрын гишүүд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндсэн хуулийн цэцийн гишүүд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлагууд зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, мөн Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нар уригдан оролцож байна.

Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч өө,

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд, төрийн түшээд ээ,

Хүндэт зочид, хатагтай, ноёд оо,

Өнөөдөр бид Монгол Улсынхаа түүх, төрт ёсны уламжлал, төрийн байгуулалтыг хүндэтгэн 1924 оны анхдугаар Үндсэн хуулийн ач холбогдол, түүхэнд гүйцэтгэсэн үүргийг эргэн санаж, Монгол Улсын ирээдүйг хамтдаа бүтээх нэгэн зорилго өвөрлөж, чуулж байна. Та бүхэнд Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойн баярын мэндийг дахин дэвшүүлж байна.

Дэлхийд суу алдраа бадраасан 2200 гаруй жилийн төрт ёсны уламжлалтай тусгаар Монгол Улс түүхийн ээдрээ нугачааны зурваст тусгаар байдлаа алдсан хэдий ч эх орныхоо цэц эрдэмт төрийн түшээд, эрэлхэг зоригт тэмцэгчдийн ач гавьяагаар тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан түүхийг бид үеийн үед санаж, энэ улсынхаа тусгаар тогтнол, ард түмэн засаглах ёсыг нандигнан хамгаалах ёстой билээ. 1911 онд Монгол үндэстэн даяар өрнөсөн хувьсгалын үрээр тусгаар тогтнолоо дахин олж тунхагласан Монгол Улс түүнийгээ цааш хадгалах, бэхжүүлэх нь тухайн цагийн дотоод, гадаадын олон хүчин зүйлээс хамаарч байлаа. Тэр цаг үеийн Манж Чин улсын уналт, Орос дахь хувьсгал, европ тивийн улсуудын зөрчилдөөн, зарим үндэстний тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, гүрэн хоорондын нууц холбоо хэлэлцээр, олон улсын хуваагдал, шинэ хүчний үүсэл зэрэг геополитикийн өөрчлөлтийн бэрхшээлтэй нөхцөл дунд Монгол Улс ард түмнийхээ өөртөө бүрэн засаглах эрхийг тунхаглаж чаджээ.

1921 оны ардын хувьсгалын дүнд ардын эрхт Засгийн газар байгуулагдаж, хэмжээт эрхт хаант төрийг тогтоосон нь эрт, эдүгээгийн уламжлалыг орчин цагийн төр улсын тогтолцоотой хослуулсан боломжит хувилбар байв. Харин Богд хаан тэнгэрт дэвшсэнээр энэ тогтолцоо цаашид хэрэгжих боломжгүйд хүрч, төрийн дээд эрх ард түмэнд буюу түүний төлөөлөгчдөөс бүрдсэн Улсын Их Хуралд шилжиж, Бүгд Найрамдах засаглалаа бүрэн утгаар тунхагласан түүхтэй. Ийнхүү одоогоос 100 жилийн өмнө Монголын аймаг, хошууд, ардын цэргийн ангиудаас сонгогдсон 77 төлөөлөгч Улсын Анхдугаар Их Хурлаар чуулж, анхны Үндсэн хуулиа 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталж, Бүгд Найрамдах Улсыг тунхагласан билээ.

Хуудас бүрд нь Ардын эрхт Монгол Улсын Хурлын тамга дарсан анхдугаар Үндсэн хуулийн эх бичиг эдүгээ үндэсний архивын сан хөмрөгт хадгалагдаж байна. Монгол Улсын анхны Үндсэн хуулийг баталсан үйл явц нь хууль тогтоох үйл ажиллагаа байсны зэрэгцээ Монголын тусгаар байдал, ард түмний засаглах хувь заяаг шийдсэн түүхэн үйл явдал байлаа. Олон ургалч үзэл бодлоор асуудалд хандах орчин цагийн Үндсэн хуулийн мөн чанар боловч энэ нь 1924 оны Үндсэн хуулийн зөвхөн саарыг нь өлгөж, сайныг нь огоорч, эсхүл дан ганц эергийг нь харж, сөргийг нь орхино гэсэн үг биш. Харин авах, гээхийн ухааныг эн тэнцүү хослуулж, улс орны цаашдын хувь заяанд гүйцэтгэсэн бодит гавьяаг хүндэтгэхийн зэрэгцээ үлдээсэн сургамжийг үеийн үед санаж, давтагдахаас сэргийлж явах ёстой юм.

Түүнчлэн өнөөдөр бид 1924 оны анхдугаар Үндсэн хуулийн утга агуулгыг орчин үеийн Үндсэн хуулиудын үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө, ардчиллын зарчмуудтай харьцуулан жишихийг урьтал болгож, уг баримт бичгийн Монголын ард түмний бүрэн эрхт засаглал, үндэсний эрх зүйн тогтолцооны цогц байдлыг бүрдүүлэхэд оруулсан хувь нэмрийг онцлон санах учиртай юм. Анхдугаар Үндсэн хуулийн төр, эрх зүйн ач холбогдол нь хаант ёсыг ард түмний засаглал болгон сольж, төрийг сонгуульт зарчмаар удирдах тогтолцоог бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөөний талаар зарим дэвшил гарган хуульчилж, Бүгд Найрамдах Улсыг

тунхаглан зарласанд оршино. Үүний зэрэгцээ Монголчууд түүхэн хүнд бэрх цаг үед анхдугаар Үндсэн хуулиа баталсан нь энэ баримт бичгийн үнэ цэнийг улам тодотгож байна.

Анхдугаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс хэмээж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн, улсын аливаа хэргийг Улсын Их Хурал ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино гэжээ. Энэ заалт нь Монголчууд Бүгд Найрамдах Улсаа тунхаглаж, төрийн эрх мэдлийг ард түмний гарт тайван замаар шилжүүлж, эрх чөлөөтэй амьдрах эрхээ эдлэх Үндсэн хуулийн баталгааг бий болгосон эрх зүйн нотолгоо мөн юм.

1924 оны Үндсэн хуулиас өмнө Богд хааны зарлигаар гадаад улсуудын хуулийг орчуулж, үндэсний онцлог, уламжлал болон өрнө, дорнын төрийн байгуулалтын шинэлэг зүйлсийг хослуулахыг эрмэлзэж байсан нь түүхийн архивд баримт болон үлджээ. Үүний нэгэн жишээ нь Богд хаан 1914 оны 02 дугаар сарын 30-ны өдөр зарлиг буулгаж, Улсын Дээд ба Доод Хурлыг байгуулж, дэлхий дахинаа янз бүрийн улсууд улсын хурал байгуулж, төлөөний хүн илгээн улсынхаа амьдралыг хэлэлцэн шийдвэрлэж байгаа тул Монгол Улсдаа ийнхүү байгуулж байгаа тухай дурдсан байдаг. Энэхүү төлөөллийн байгууллагын ерөнхий тогтолцоог анхдугаар Үндсэн хуульд уламжлан шингээж, Дөрөвдүгээр зүйлд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн хурлын чөлөөт цагт Улсын Бага Хуралд хадгалуулах ба бас мөн хурлын чөлөөт цагт Бага Хурлын тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино гэж тусгасан. Ийнхүү ард түмэн засаглах эрхээ хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болох сонгуульт байгууллагын тогтолцоо нэвтэрсэн нь өнөө цагийн парламентын зарим шинжийг агуулж байв.

Нэгэн зууны тэртээх энэхүү Үндсэн хуулиар худалдаачид, ван, гүн, хутагт, лам нарын сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан зэрэг хожим хойно засаж залруулсан дулимаг заалтууд байсны зэрэгцээ орчин цагт бидний эдэлж буй олон үндсэн эрхийн суурь тавигдсаныг онцлон дурдъя. Тухайлбал эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш байх, шашин ба төрийн үйл хэргийг тусдаа буюу шашин шүтлэгийн эрх чөлөөтэй байх, эрдэм боловсролд үнэ төлбөргүй суралцах эрх, хэвлэн нийтлэх, шүүмжлэх эрх чөлөө зэргийг хуульчилсан нь эдгээр эрхийн цаашдын хөгжилд түлхэц болсон нь дамжиггүй. Ардчилсан Үндсэн хуульд буй ард түмэн байгалийн баялагтаа эзэн байх зохицуулалтын агуулга нь зуун жилийн өмнөх Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялгууд бол эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртал нь чухам одоогийн ард улсын ёсонд нийцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно гэж тусгалаа олж байсныг эрдэмтэд онцлон тэмдэглэжээ.

Үүнийг 1992 оны ардчилсан Үндсэн хуульд уламжлан авч хөгжүүлэн, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр агуулгыг нь хөгжүүлж байгалийн баялгийг одоо ба ирээдүй үеийн тусын тулд урт хугацааны, тогтвортой хөгжлийн бодлогод тулгуурлан ашиглах, үр өгөөжийг ард түмэн хүртэх, иргэдэд өмчлүүлснээс бусад баялаг төрийн нийтийн өмч байх баталгааг бүрдүүлээд байна. Ийнхүү Монголчууд дэлхий дахинаа Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хуулиа баталснаар зүүн болон төв азид Япон, Хятад улсын хамт

Үндсэн хууль бүхий эхний гурван улс болж, тэргүүлж хөтөлсөн түүхтэй. Монгол Улс энэ зуун жилийн хугацаанд Үндсэн хуулиа бүтэц, бичвэр, агуулга, мөн чанарын хувьд тасралтгүй хөгжүүлж өнөө цагийн ардчилсан Үндсэн хуулиа бүтээсэн гэдгийг цохон тэмдэглэе.

Тиймээс Монгол төрийн үндсэн хуульт ёсны хөгжилд анхдугаар Үндсэн хуулийн оруулсан хувь нэмэр, ард түмэн засаглах Бүгд Найрамдах Улсын хөгжилд гүйцэтгэсэн үүргийг хүндэтгэн, Монгол Улсын Их Хурал 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр “Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” 64 дүгээр тогтоол гаргаж, энэхүү үйл явдлыг улс орон даяар төгөлдөр тэмдэглэхээр тогтоосон. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд олон нийтийг хамарсан болон төрт ёсны хүндэтгэлийн арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа. Тухайлбал анхдугаар Үндсэн хуулийн түүхэн ач холбогдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судалсан бүтээлийг хэлэлцсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг судалгааны хүрээлэн, эрдэмтэн, судлаачдыг хамруулан зохион байгуулж, түүх, архивын эх сурвалжийг эргэлтэд оруулах ажлыг идэвхжүүлсэн нь сайшаалтай.

Түүнчлэн залуу хойч үедээ анхдугаар Үндсэн хуулийн түүхэн утга учрыг бодитойгоор таниулан ойлгуулах зорилгоор уран бүтээлчид баримтат бүтээлүүдийг туурвиж, анхдугаар Үндсэн хуулийг хэрхэн боловсруулж, баталж байсан талаарх архивын сан хөмрөгийг нийтэд дэлгэн харуулах ажлыг хэрэгжүүлсэнд талархаж байна.

Эрхэм нөхөд өө,

Ардчилсан Үндсэн хуульд 2023 онд оруулсан өөрчлөлтөд тусгагдсан сонгуулийн холимог тогтолцоо нь парламентын дархлааг нэмэгдүүлэх, төлөөлөх чадварыг өргөжүүлэх замаар парламентат ёсыг бэхжүүлэхийг зорьсон. Энэ зорилго хэрэгжиж өнөөдөр Улсын Их Хуралд 5 намын төлөөлөл бүхий 126 гишүүн сонгогдож, олон салбар чиглэлээр мэргэшсэн, нас насны төлөөллийг хангасан бүрэлдэхүүнтэй болж, олон ургалч үзэл хангагдах нөхцөл бүрджээ. Монгол Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн дүнд бүрдсэн парламент Үндсэн хуулийн эрхэм зорилгод үндэслэн Стратеги төлөвлөгөөгөө баталж, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, олон ургалч үзлийг хангах, үр нөлөөтэй байх, ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх, ёс зүйтэй, хариуцлагатай, хариуцан тайлагнадаг байх үнэт зүйл болгон тодорхойллоо. Ингэснээр Улсын Их Хурал хууль тогтоох болон хянан шалгах бүх үе шатад хүн төвтэй үзэл санаанд суурилсан, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалсан байх агуулга, шаардлагыг нэн тэргүүнд тавин ажиллана.

Монгол Улсын Их Хурал өнөө цагийн Үндсэн хуулийн онцгой чухал зарчим болох ард түмэн засаглах Бүгд Найрамдах Улсын эрх зүйн үндсийг тогтоосон анхдугаар Үндсэн хуулийн түүхэн ач холбогдлыг тэмдэглэж, ард түмэн бид бүрнээ дагаж мөрдвөл зохих 1992 оны Үндсэн хуулиа дээдлэн залах тухай тогтоолыг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр баталсныг төрийн байгууллагууд цаашид мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Бид өнөөдөр Бүгд Найрамдах Улсыг тунхагласан анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн түүхэн ойн өдөрт хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ цаашид бүгд найрамдах ёс, ард түмний засаглал, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг уламжлан дамжуулах төрийн байгуулалт, төрт ёсыг бэхжүүлэх санаа зорилго нэг байгаа гэдэгт итгэл дүүрэн байна.

Өнөөгийн бидний үүрэг бол эх орныхоо тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтийн төлөө эв эеийг эрхэмлэж, хариуцлагатай байх явдал билээ. Монгол Улсын энэ цагийн Үндсэн хуулийг бүрнээ хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хуулийг дээдэлж, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах үйл хэрэгт улам бүр шамдахын ерөөл дэвшүүлье. Та бүхэндээ Монгол Улсын анхны Үндсэн хуулийн 100 жилийн ойн баярыг хүргэж, дахин хүргэж, мэндчилж байна. Ажлын амжилтыг хүсье.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх таныг Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тохиолдуулан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд үг хэлнэ үү хэмээн индэрт урьж байна.

У.Хүрэлсүх: Бүрэн эрхт, эрх чөлөөт, тусгаар тогтносон Монгол Улсын ард иргэд ээ,

Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, эрхэм төрийн түшээд ээ,

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,

Манай улсад суугаа эрхэм хүндэт Элчин сайд нар аа,

Та бүхэнд анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны түүхт 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье. Чин зоригт, эх оронч өвөг дээдсийн баатарлаг тэмцлийн үр дүнд 1911 оны цагагчин гахай жил Үндэсний эрх чөлөөний хувьсгал гарч, туурга тусгаар улсаа сэргээн байгуулах гэсэн Монголын ард түмний чинхүү хүсэл эрмэлзэл, тэмүүлэл биеллээ олж, улмаар тусгаар тогтнолоо бататган бэхжүүлэх Ардын хувьсгалын үндэс суурийг тавьсан түүхтэй билээ.

Энэхүү түүхэн үйл хэрэг бол ноёд язгууртан, лам хувраг, эгэл ард бүх нийтээрээ эх оронч үзлээр эвлэлдэн нэгдсэн үндэсний эв нэгдлийн хүч байсан гэж хэлж болно.

Тусгаар тогтнолын төлөөх мохошгүй тэмцэл 13 жилийн туршид зогсолтгүй үргэлжилсний үр дүнд 1921 оны 07 дугаар сарын 11-нд Ардын хувьсгал ялж, хожим 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр буюу Монгол Улсын 14 дүгээр оны модон хулгана жилийн өвлийн дунд сард Монгол түмний хувь заяаг эргүүлсэн 20 дугаар зууны нэгэн сод үйл явдал болсон нь Улсын анхдугаар Үндсэн хуулийг, анхдугаар Их Хурал хуралдаж, Үндсэн Хуулийг батлан, Бүгд Найрамдах засгийг дэлхий дахинд тунхаглан зарласан явдал юм. Богд хаант Монгол Улсын үеэс Үндсэн хуулийг боловсруулан батлах бодлогыг хэрэгжүүлж байсан бөгөөд 1914 онд Монгол Улсын Ерөнхий сайд Намнансүрэнгийн даалгавраар Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлыг эхлүүлж байсан түүхтэй байна.

Энэхүү ажлын хүрээнд Ерөнхий сайд Намнансүрэнгийн тушаалаар эрдэмтэн Жамсрангийн Цэвээн 1914-1915 онд дэлхийн улсууд, түүн дотроо өрнөдийн улс орнуудын хууль, эрх зүй, төрийн байгууламж, засгийн хэлбэр, улс тус бүрийн онцлогийг Үндсэн хуулиар хэрхэн зохицуулж буйг харьцуулан судалж, Улсын эрх хэмээх бүтээлийг туурвисан байдаг. Тэр бээр Герман, Австри Венгер, Англи, Итали, Бельги, Голланд, Дани, Швейцар, Испани, Португал, Орос, Япон зэрэг улс орны Үндсэн хууль, Үндсэн хуулийн эрх зүйг судалж байсан нь анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах үндэс суурь, чухал алхам болсон төдийгүй эдүгээ ч

үнэ цэнээ алдаагүй хэвээр байна. Хожим 1921 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн Ардын түр Засгийн газрыг байгуулсан тогтоол, Засгийн газрын 1921 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн тогтоолуудад Үндсэн хууль боловсруулах тухай тус тус заасан байдаг.

Түүний дараагаар 1924 оны 09 дүгээр сард Ардын Засгийн газрын Ерөнхий сайд Цэрэндоржоор ахлуулсан Үндсэн хууль боловсруулах комиссыг байгуулан ажиллуулсан байна. Шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах, батлах үйл явцад тухай үеийн Зөвлөлт Орос Улс, Коминтерны нөлөө, түүний төлөөлөгч Элбэгдорж Ринчино, Турар Рыскулов зэрэг хүмүүсийн шахалт, дарамт орсон нь хэдий үнэн ч анхдугаар Үндсэн хууль бүхэлдээ манай ард түмэн, төр засгийн бодлогын тусгал болон батлагдсан хэмээн эрдэмтэн судлаачид үзэж байна. Эдгээр түүхэн баримтуудаас дүгнэн үзвэл анхдугаар Үндсэн хуулийг Ерөнхий сайд Намнансүрэнгийн төсөлд тулгуурлан, Ерөнхий сайд Бодоо, Жамсрангийн Цэвээн нарын санал, төслийг харгалзан үзэж, тухайн үеийн хувьсгалын удирдагчдын манлайлал дор боловсруулсан болох нь тод харагдаж байгаа юм.

Эрхэм хүндэт нөхөд өө,

Хүний нийгмийн хөгжил гурван цагийн алтан хэлхээ, амьд шүтэлцээнд үргэлжилдэг. Өчигдөргүй өнөөдөр, өнөөдөргүй маргааш гэж үгүй. Өнгөрснийг үнэлж дүгнэхдээ эдүгээчлэх, нам, улс төр, хувь хүний үзэмжээр хандах, засварлах, гоёчлох, туйлшрах, эсхүл ердөө л бусдад таалагдах үүднээс хандах зэрэг нь нэн осолтойг бид байнга бодож ёстой. Буруу замаар орж будилах, алдахын эхлэл чухамхүү эндээс үүддэг гэдгийг өнөө цагийн төрийн түшээд, төрийн албан хаагчид ямагт санаж явах учиртай юм. Түүхэн үйл явдлыг тухайн цаг үеийнх нь нөхцөл байдал, онцлог, шалтгаан хийгээд үр дагавар, зайлшгүй ба санамсаргүйн хэлхээ холбоонд авч үзэх нь хамгийн зөв зарчим, арга зүй мөн байдаг. Чухам энэ зарчмаар анхдугаар Үндсэн хуулийн түүхэн ач холбогдлыг бид дүгнэн цэгнэх ёстой.

20 дугаар зууны эхэн үеийн дэлхий дахины улс төр, геополитикийн нөхцөл байдал, ялангуяа манай хоёр хөршийн зүгээс Монгол Улсын тусгаар байдалд хандах хандлага ихээхэн ээдрээ төвөгтэй байсныг бид бүгд мэднэ. Монголын эрх баригчид Зөвлөлт, Хятадын удирдагчидтай уулзахдаа Монгол Улс тусгаар байдлаа ямагт хадгалах бөгөөд Дундад иргэн улсын нэг хэсэг болохыг хэзээ ч, хэрхэвч хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ хоёрдмол утгагүйгээр, итгэл төгс, эрс шийдэмгий илэрхийлж байсан нь түүхэн үнэн юм. Түүх түүхээрээ л үлддэг. Ийм эгзэгтэй цаг үед Монгол төрийн удирдагч, зүтгэлтнүүд улс төр, дипломатын уран хурц нүүдэл хийж, тусгаар тогтнолоо баталгаажуулан, улс гэрээ мандуулах арга эвийг эрэлхийлж, энэхүү эрхэм зорилгоо алхам алхмаар бататгасаар байсныг бас түүх гэрчилдэг. Дамдины Сүхбаатар, Догсомын Бодоо, Солийн Данзан, Дансранбилэгийн Догсом, Догсомын Лосол, Дамбын Чагдаржав, Хорлоогийн Чойбалсан нарын зоригт хөвгүүд Ардын намыг анх байгуулж, улмаар эх оронч бүх хүчнийг тэмцэлд уриалан дуудаж, Ардын хувьсгалыг ялалтад хүргэсэн нь өөрийн газар нутагтаа эзэн суух гэсэн Монголчуудын чин хүслийн биелэл, мөнх тэнгэрийн таалал байсан юм.

Гэвч энэ бол их зохиолч Нацагдоржийн өгүүлсэнчлэн зөвхөн нарыг хэвээр үлдээж, хуучны хэв ёсыг үндсээр нь эвдэх их өөрчлөлтийн эхлэл гэж үзэж болно. Хуучныг халж, шинэ засгийг, засаг төрийг эмхлэн байгуулна гэдэг амар бүтэх ажил

биш байлаа. Дэлхийн аль ч улсын түүхэнд ноёрхогч анги байсан анги, ноёрхогч анги сайн дураараа эрх мэдлээсээ татгалзаж байсан түүх ховор. Харин цус урсгасан олон жилийн ширүүн тэмцэл, иргэний дайнаар шийдэгдсэн гашуун түүх, сургамж цөөнгүй байдгийг дэлхий нийтээрээ мэднэ. Харин тухайн үеийн нам, төрийн зүтгэлтнүүд иргэний дайнд хүргэлгүйгээр чадвал зөөлөн, ядвал хатуу аргаар бошгыг халах бат журмаар үйлдэнэ хэмээн олон түмэнд тунхаглан зарлаж, аль болох тайван замаар засаг төрийн эрхийг шилжүүлэхийг хичээсэн нь туйлын ухаалаг бодлого байсан гэж хэлж болно.

Нийслэл хүрээг чөлөөлсний дараа Богд хаантай тангаргийн гэрээ байгуулж, төрийн нүсэр албыг Ардын Засгийн газарт, түмэн олон, лам хувраг нарын шашны хэргийг хэмжээт эрхт хаанд үүрүүлэхээр тохиролцож чадсаны хүчинд 1921-1924 онд томоохон ардчилсан өөрчлөлтүүдийг харьцангуй тайван замаар хэрэгжүүлсэн гэж судлаачид үзэж байна. Мөн Ардын Засгийн газар 1923 оны нэгдүгээр сард Нутгийн захиргааны дүрэм хэмээх Үндсэн хуулийн шинжтэй баримт бичгийг баталж, нутгийн захиргааг 10 гэр, баг, сум, отог, хошуу, аймаг гэсэн бүтэцтэй болгож, тус бүрд хурал байгуулах, угсаа залгамжлах ёсыг устгаж, аливаа тушаалтныг сонгуулийн журмаар тавих болсон нь одоогийн хэллэгээр эрх зүйн шинэтгэлийн эхлэл болсон гэж болно.

Дээр дурдсан олон чухал арга хэмжээг Ардын Засгийн газар 1921-1924 онд авч хэрэгжүүлж байсан бол Улсын анхдугаар Их Хурлыг зарлан хуралдуулж, анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах засгийг тунхаглан зарлах нөхцөл бүрдэхгүй байсан хэмээн судлаачид бас үзсэн байна.

Эрхэм төрийн түшээд ээ,

Ардын Засаг анхдугаар Үндсэн хуулийг хэлэлцэн батлах Улсын анхдугаар Их Хурлын төлөөлөгчдийг жинхэнэ ардчилсан зарчмаар сонгох, тэдгээрийн бүрэлдэхүүнд халх дөрвөн аймаг, их шавь болон дөрвөд, казах, буриад, алтайн ба Хөвсгөлийн урианхай, Ховдын тариачин хошуу зэрэг ястан угсаатны төлөөллийг заавал оролцуулахад онцгой анхаарч бас багагүй хугацаа үүнд зарсан байдаг. Шат шатны хурлын үр дүнгээр, өндөр босгыг давж сонгогдсон төлөөлөгчид Их Хурлын ажилд туйлын идэвхтэй оролцсон бөгөөд төрөө дээдлэх ёс, түмнээ төлөөлөх хариуцлагыг гүнээ ухамсарлан, 20 өдөр амралтгүй хуралдан, их үйлсийг бүтээсэн түүхийг өнөөдөр ч эрхэм гишүүд та бүхэн гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй гэж хүсэж байна.

Үндсэн хуулийн төслийг Ерөнхий сайд Цэрэндорж 1924 оны 11 дүгээр сарын 25-нд танилцуулж, 77 төлөөлөгч хоёр өдөр зүйл тус бүрээр хэлэлцэн, Улсын анхдугаар Их Хурлаар буюу 1924 оны 11 дүгээр сарын 26-ны үдийн хойно 4 цаг 17 минутад 6 бүлэг, 50 зүйл бүхий Үндсэн хуулийг баталж байсан түүхтэй байна. Энэ бол төрт ёсны өнө эртний түүхтэй Монголчууд бидний хувьд анх удаа бичмэл Үндсэн хуультай болсон гайхамшигтай түүх байсан юм. Анхдугаар Үндсэн хуулийн түүхэн ач холбогдол, өнөөгийн бидний амьдралд хэрхэн уялдаж буй талаар цөөн хэдэн зүйлийг хэлье.

Нэгдүгээрт, Анхдугаар Үндсэн хуулиар улс орныхоо бүрэн эрхт байдлыг тунхаглан зарлаж, эдийн засаг, аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадлыг бататган бэхжүүлэх эхлэлийг тавьж чадсан гэж үзэж байна. Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд Бүгд Найрамдах Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах

Бүрэн Эрхт Ард Улс хэмээж улсын дээд эрхийг жинхэнэ ардад эдлүүлэхээр зааж, 1921 оны хувьсгалаас өмнө Монголын эрх баригчдын гадаадтай байгуулсан гэрээ бичгүүд, зээлсэн мөнгө, өр төлбөр бол гадаадаас хүчирхэн хүлээлгэсэн болох тул цөмийг устгасанд тооцно, мөн гадаад улсуудтай харилцах, улс төрийн ба худалдааны гэрээ бичиг тогтоох, концесс ба монополын эрх олгох, устгах, улсын хил хязгаарыг өөрчлөх, байлдах, найрамдах, цэргийн хүчнийг байрлуулах зэрэг явдлыг улсын дээд эрхийг барих газруудын эрхлэн шийтгэх зүйлс мөн хэмээн тогтоохын зэрэгцээ, Анхдугаар Үндсэн хуулийн оршил хэсэгт Богд хааны тамгыг Засгийн газар шилжүүлэн залж хадгалах, Хаант Засгийг халж, цаашид Бүгд Найрамдах Засгийг тогтоон Да жунтан гэдэг ерөнхий даргыг сонгохгүй, улсын бүх дээд эрхийг Улсын Их Хурал ба мөн Хурлаар сонгогдсон Засгийн газар хадгалахаар энэ хуульд зүйлчлэн зааж өгсөн байна. Ийнхүү бидний орчин цагийн ардчилсан улсын түүх эхэлсэн гэдгийг бид огт мартаж болохгүй.

Мөн улсын аж ахуй ба эдийн засгийн бодлогыг чухалчлан үзэж байсан бөгөөд Үндсэн хуульд улсын орлого, зарлагыг төсөвлөсөн дансанд нэгтгэж, улсын төсвийг үр ашигтай захиран зарцуулахад хатуу чанд сахилгыг тогтоож өгсөн байна. Түүнчлэн улс орноо батлан хамгаалах өөрийн гэсэн хүчнийг буй болгохыг зорьж, Үндсэн хуулиар тогтоож байсан нь өнөөгийн Үндсэн хуульд Монгол Улс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байна хэмээх заалтаар уламжлагдан хэрэгжиж ирснийг бас энэ хуулиас харж болно.

Хоёрдугаарт, Анхдугаар Үндсэн хуулийн бас нэгэн томоохон ололт нь анх удаа хүний эрх, эрх чөлөөг тунхаглаж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тогтоож өгсөн явдал юм. Анхдугаар Үндсэн хуульд Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс хэмээнэ гэж тунхаглан, ард иргэдийнхээ эрх, эрх чөлөөг баталгаажуулахдаа эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг хангаж, түүн дотроо эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил, тэгш эрхийн үндсэн дээр сонгох, сонгогдохоор заасан нь ази тивдээ анхдагч ардчилсан Үндсэн хууль болсон гэж судлаачид дүгнэн цэгнэж байна. Тэгвэл ардчилсан гэгдэх барууны орнуудаас эмэгтэйчүүдийн сонгуульд оролцох эрхийг 1944 онд Франц улс, 1948 онд Баруун Герман, 1971 онд Швейцар, 1974 онд Португал, 1975 онд Грек, 1976 онд Испани нээж өгсөн бол анхны бичмэл Үндсэн хуулийг баталсан Америкийн нэгдсэн улс хүйсээр үл ялгаварлан эмэгтэй, эрэгтэй хүнд адил цалин хөлс авах тухай хуулийг 1963 онд баталж байсан байна.

Анхдугаар Үндсэн хуулийн дээрх үзэл санаа өнөөгийн парламентад ч тусгалаа олж, эмэгтэйчүүдийн парламентад сонгогдох боломжийг нэмэгдүүлэх талаар онцгой анхаарсны үр дүнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар 32 эмэгтэй сонгогдож, нийт гишүүний 25 хувийг бүрдүүлсэн нь ази тивдээ парламент дахь эмэгтэй гишүүдийн төлөөллөөр тэргүүлэх үзүүлэлт болсныг энэхүү түүхэн өдөр тэмдэглэн хэлэхэд сайхан байна. Монгол нийт бүсгүйчүүддээ, ээж нартаа, эхчүүддээ улс төрийнхөө эрх чөлөөг олж авсан 100 жилийн ойн баярын мэндийг хүргэе.

Гуравдугаарт, Үндсэн хууль нэгэнт улс төр, эрх зүйн баримт бичиг болохын хувьд анхдугаар Үндсэн хуулиар Монгол Улсын гадаад бодлого, түүний хэтийн чиглэлийг оновчтой тодорхойлсон байна. Тухайн үеийн нам, төрийн удирдагчид гадаад, дотоод улс төрийн нөхцөл байдал улам хүндэрч байсан аянгат цагийн амаргүй, эгзэгтэй үед улс төр, дипломат харилцаанд өчүүхэн боловч алдаа гаргахгүйг хичээж, туйлын хянуур болгоомжтой хандан анхдугаар Үндсэн хуульдаа

Бүх дэлхийн жинхэнэ ард түмний зорилго нь одоогийн эзэрхэг хөрөнгөтний байдлыг үндсээр устгаж, нийгэм журамт ба эв хамт ёсыг эрхэмлэх тул бидний жинхэнэ ард улсаас гадаадтай харилцах засгийн бодлогыг бүх дэлхийн бага буурай улс ба хувьсгалт ард түмний ашиг тус, үндсэн зорилготой нийцүүлж явуулна хэмээн заасан байна.

Мөн цагийн байдлыг хянаж, ямар ч гадаад улстай харилцан найрамдаж болох боловч бидний улсын бүрэн эрхэд халдах этгээд бий ахул бүхий л хүчээр эсэргүүцнэ хэмээн энх тайванч гадаад бодлого явуулахаа дэлхийн улс түмэнд анх удаа зарлан тунхаглаж байсан түүхтэй юм. Энэхүү бодлого нь эдүгээ ч ач холбогдлоо алдаагүйн дээр Монгол Улсын энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын эх үндэс болон одоо ч өргөжин тэлж байгааг та бид бүгдээрээ харж байгаа. Түүх ингэж эхэлсэн байна.

Түүнчлэн тусгаар тогтносон Монгол Улсын бүрэн эрхэд хэн нэгэн этгээд халдах аваас шууд эсэргүүцэн тэмцэнэ, ямар нэгэн буулт, яриа хэлцэл хийхгүй гэдэг жанжин шугамаа тууштай илэрхийлж ирсэн байна. Тухайн үеийн түгшүүрийн харанга дэлдсэн эгзэгтэй нөхцөл байдалд адгаж бачуурч, сандарч тэвдэлгүй, хийх алхмуудынхаа ээлж дарааллыг нарийн зөв тооцож, алсыг харсан байр сууриа тодорхойлж чадсан энэхүү гадаад бодлого нь цаг хугацааны олон сорилт, шалгуурыг амжилттай даван туулсан бөгөөд үүнийг Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүнээр элссэн 1961 он хүртэлх түүхэн үйл явдлууд нотлон харуулдгийг та бид бүгдээрээ мэднэ.

Хожим баруунтан хэмээн буруутсан тэр үеийн удирдагчид Зөвлөлт Орос улстай харилцаагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Монголыг гадаад гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх боломжийг эрэлхийлж байсан түүхтэй. Герман, Англи, Америк, Япон зэрэг орны элчин сайд, дипломат төлөөлөгчидтэй уулзаж, харилцаа тогтоох хүсэлтэйгээ илэрхийлж, Германд Монголын худалдааны төлөөлөгчийн газрыг нээж, Франц, Герман улсад Дашдоржийн Нацагдорж, Пагмадулам нарын 40 орчим хүүхэд, залуусыг сургахаар илгээсэн зэрэг нь тэрхүү гадаад бодлогын тод илэрхийлэл гэж болно.

Харамсалтай нь анхдугаар Үндсэн хуулийнхаа заалтуудыг хэрэгжүүлэхийн төлөө зүтгэж байсан хүмүүс түүхийн ээдрээ, нугачаатай он жилүүдэд хэлмэгдсэнээр бусад улс оронтой харилцаж, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх гэсэн оролдлого нэг хэсэгтээ зогссон түүхтэй. Дан ганц Зөвлөлт Орос улсаар хүлээн зөвшөөрөгдсөн байх нь хангалтгүй, бусад улс оронтой хэлэлцээр хийх ёстой, үлгэрлэвээс Швейцар лугаа адил төвийг сахисан улс болохыг эрмэлзэх ёстой гэсэн Жамсрангийн Цэвээн, мөн Монгол Улстай харилцахаас татгалзаагүй л бол дэлхийн бүх улс оронтой ойртон нөхөрлөх гэсэн Догсомын Бодоо, Балингийн Цэрэндорж, Анандын Амар, Цэрэн-Очирын Дамбадорж, Наваандоржийн Жадамба зэрэг тухайн үеийн нам, төрийн зүтгэлтнүүдийн баримталж байсан байр суурь өнөөгийн Монгол Улсын гурав дахь хөршийн бодлогын үндэс суурийг тухайн үед томьёолж байсан гэж үзэх үндэстэй юм.

Дөрөвдүгээрт, Манай улс 1924 онд анхны Үндсэн хуулиа баталснаар ази тивийн Үндсэн хуультай анхны улсууд болох Япон, Иран, Афганистан зэрэг улстай хамт бичигдэж, ази тивд Үндсэн хуульт ёсыг хөгжүүлж ирсэн тэргүүлэх улс орнуудын дотор зүй ёсоор багтдаг хэмээн Үндсэн хуулийн эрдэмтэн,

судлаачид дүгнэн бас үзэж байна. Энэхүү анхдугаар Үндсэн хуулийг боловсруулахад Зөвлөлт Орос улсаас туслалцаа, дэмжлэг авсан нь тухайн үеийн нөхцөл байдлаас үүдсэн бодит үнэн бөгөөд энэ нь нэг талаасаа манай орны эрх зүйн тогтолцоо эх газрын эрх зүйн бүлээс улбаатай болсны нэгэн нотолгоо гэж хэлж болно. Анхдугаар Үндсэн хуулиар Хаант засгийг халж, Бүгд Найрамдах засаглалыг тогтоосон нь манай улсын өнгөрсөн зууны хөгжил дэвшлийн үндэс суурь, өнөөгийн ардчилсан Монгол орны төрийн байгууламжийн үндсэн хэлбэр болон хөгжин бэхжиж байна.

Ийнхүү анхдугаар Үндсэн хууль нь Үндсэн хуульд ёсны үзэл санааг түүчээлэн хөгжүүлэх зам мөрийг тавьж, нийгмийн өөрчлөлт, цаг үеийн онцлогийг тусгасан 1940 он, 1960 он, 1992 оны Үндсэн хуулиудыг бид нар батлан гаргах хөрс суурь болсон юм. Монгол Улсын анхдугаар болон 1940, 1960 оны Үндсэн хуулиуд нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, төрийн байгууллын тогтолцоог хуульчлан бэхжүүлж ирснээрээ онцгой ач холбогдолтой, нийтлэг шинжтэй бөгөөд тухай цаг үеийн улс орны хөгжил дэвшилд өөрийн, өөр өөрийн түүхэн үүргээ зүй ёсоор биелүүлж ирсэн түүхтэй.

Монгол оронд 1980-аад оны сүүл, 1990-ээд оны эхэнд өрнөсөн ардчилсан өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнд Монголчууд бид үндэсний язгуур эрх ашиг, ардчилсан үзэл санааны төлөө эвлэлдэн нэгдэж, улс төр, нийгэм, эдийн засаг, оюун санааны шинэ тогтолцоонд шилжиж чадсан нь манай улсын түүхийн бас нэгэн онцгой гайхамшигтай үйл явдал болсон гэж хэлж болно. Шинэ Үндсэн хуулийг боловсруулж, ард түмнээр хэлэлцүүлж, баталсан үйл явц нь Монголчууд бидний үндэсний их зөвшилцөл, үзэл санааны дэвшил байсан гэж хэлж болно. Ардчилсан шинэ Үндсэн хууль нь Монголын ард түмний амьдралд түүхэн шинэ эргэлт болж, тусгаар тогтнол бүрэн эрхт байдлаа бататган бэхжүүлж, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх үндэс суурь болсон билээ.

Энэхүү Үндсэн хуулийн үр дүнд хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч, иргэний нийгэм, ардчилсан сонгууль, олон намын тогтолцоо, нутгийн өөрөө удирдах ёс зэрэг ардчилсан нийгмийн үндэс суурийг бэхжүүлж чадсан. Монгол Улсын үндсэн хуульд ёсны 100 жилийн түүхэн хөгжил нь аливаа эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай байх зарчимд суурилан төр, засгийн эрх мэдлийг Үндсэн хуулиар тогтоож, хүний эрх, эрх чөлөөг хамгаалан баталгаажуулж, эрх зүйт төрийг байгуулахын төлөөх нэгэн зууны нөр их хичээл зүтгэл, эрэл хайгуул, сургамж, туршлага, бидний түүх, өв соёл, үнэт зүйл болсон юм. Монголын ард түмний Үндсэн хуульд ёсны энэхүү баялаг түүх нь зөвхөн манай ард түмний түүх, өв соёл төдийгүй хүн төрөлхтний Үндсэн хуульд ёсны түүхийн салшгүй нэг хэсэг болно.

Өнгөрсөн зууны түүхийг товчилж хэлбэл бидний өвөг дээдэс Бүгд Найрамдах Улсаа тунхаглаж, тусгаар тогтнолоо зарлан, даян дэлхийд улс орноо хүлээн зөвшөөрүүлж, Хүннү гүрэн, Их Монгол Улсын гал голомтыг сэргээн бадрааж, орчин цагийн ардчилсан Монгол Улсыг цогцлоон байгуулсан тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн агуу зуун байсан гэж болно. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, 1921 оны Ардын хувьсгал, 1939 оны Халхын голын дайлдаан, 1945 оны Чөлөөлөх дайн, 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнээр элссэн хийгээд, 1990-ээд оны ардчилсан өөрчлөлт, шинэчлэлт зэрэг сүүлийн хоёр жаранд тохиосон манай улсын нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны гайхамшигт өөрчлөлтүүд нь агуу түүхт Монголын ард түмний язгуур эрх ашиг, үндэсний эв нэгдэл, хамтын хүчээр сэргэн мандсан эх оронч үзэл санааны

ялалт байсныг түүхт баярын энэ ойн өдөр тэмдэглэн хэлэхэд бахдам сайхан байна.

Эрхэм хүндэт ард иргэд ээ,

Эрхэм хүндэт Монгол төрийн түшээд ээ,

Одоогоос 100 жилийн өмнө Монголчууд бид эрх чөлөө, тусгаар тогтнолоо сонгож, улсынхаа бүрэн эрхт байдлыг Үндсэн хуулиараа баталгаажуулж чадсан бол Монгол Улстай сайн харилцаа тогтоохыг хүссэн бүх оронтой найрамдан нөхөрлөх өвөг дээдсийнхээ чинхүү хүслийг эдүгээ цагт бид биелүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх гишүүн орон болох 192 улстай дипломат харилцаа тогтоох зорилтоо манай улс бүрэн хангаж хэрэгжүүлж чадсан гэдгийг баярын энэ өдөр хэлэхэд сайхан байна. Үе үеийн чин зоригт, эх оронч өвөг дээдсийн халуун амь, бүлээн цусаар дархлагдсан Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хөгжил дэвшлийг өнөө цагт өртөөлөн, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх нь та бидний эрхэм үүрэг, түүхэн хариуцлага юм.

Иймд цаашид бид шинэ Үндсэн хуулиар баталгаажуулсан Монголын ард түмний ололт амжилт, үнэт зүйл болсон ардчилсан төр, засаг, парламент ёсоо бэхжүүлж, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийн төлөө төр, засаг, улс төрийн нам, эвсэл, иргэний нийгэм, ард түмнээрээ хамтран хүчин зүтгэх учиртай. Эрх зүйт төртэй улсад үндэстний эв нэгдлийн хүчээр Үндсэн хуулиа баталж, Үндсэн хуулиараа үндэстний эв нэгдлээ хангадаг жамтай юм. Эв нэгдэл үгүй бол улс үндэстэн тогтнож, улс үндэстэн хөгжин дэвжих боломж байхгүй. Хоёр хүн эвтэй бол төмөр хэрэм мэт, хорин хүн эвгүй бол нурсан балгас мэт гэж хэмээх Их эзэн Чингис хааныхаа билиг сургаалыг ямагт санаж, эрх чөлөө, тусгаар тогтнол, эв нэгдлээ бататган бэхжүүлж, эвийг эрхэмлэж, зөвийг тэтгэж, ёсыг сахиж амьдрах нь Монголчууд бидний хөгжил дэвшил, мандан бадрахын үндэс байх болно гэдгийг Монгол хүн болгон зүрх сэтгэлдээ тээж, бодож явах ёстой.

Тиймээс анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласан энэ өдөр бол Монголчууд бидний улс үндэстэн, тусгаар тогтнолоороо бахархах үндэстний их бахархлын өдөр мөн гэдгийг хэлэхийг хүсэж байна. Энэ бахархлын эзэн нь эрх чөлөөт Монголын ард түмэн та бид билээ. Учир иймээс манай ард түмэн эзэн Чингис хааны байгуулсан Их Монгол Улсын гал голомтыг сахин суугаагаа гүнээ ухамсарлан, төрт ёсны үнэт зүйл, өв соёл, үүх түүх, Үндсэн хуулиа эрхэмлэн дээдэлж, хойч үедээ өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс Монголоо мандуулахын төлөө улс үндэстнээрээ хамтдаа хүчин зүтгэхийг түүхт ойн баярын энэ өдөр Төрийн тэргүүн ард түмэндээ уриалж байна.

Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулганд үг хэлсэн Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх танд талархал илэрхийлье. Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” 43 дугаар тогтоолыг баталсан. Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, дугаар 43, Үндсэн хуулиа дээдлэн залах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Бүгд Найрамдах Улсын үндэс тулгуурыг тогтоон Үндсэн хуульд тусгаар улсыг тунхаглан зарласан анхдугаар Үндсэн хуулийн түүхэн ач холбогдлыг тэмдэглэж, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл, иргэншлийн ололтыг хүнд хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталсан ардчилсан шинэ Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, нийт байгууллага, иргэний үйл ажиллагааг Үндсэн хуульд бүрнээ нийцүүлэх, мэдэгтүн, сахигтун гэж орон даяар олноо зарлан тунхагласныг сахин биелүүлэх зорилгын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тогтоосугай.

1.Төрийн бүх байгууллага, Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар Үндсэн хуулиа дээдлэн залсугай.

2.Иргэн бүр Үндсэн хуулиа судлан мэдэж, айл өрх бүр Үндсэн хуулиа дээдлэн залахыг уриалсугай.

3.Үндсэн хуулийн агуулга, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусган, түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулахыг Монгол Улсын Засгийн газар болон холбогдох бусад төрийн байгууллагад даалгасугай.

4.Үндсэн хуулийн агуулга, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулах, сурталчлахыг хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай.

5.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандоржид даалгасугай.

6.Энэ тогтоолыг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс дагаж мөрдсүгэй. Ингээд уг тогтоол 21-ний өдөр батлагдсан, өнөөдрөөс албан ёсоор хэрэгжиж эхэлж байгаа гэдгийг нэмж хэлье.

Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Та бүхэнд баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.УЯНГА